

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭД 2016 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**С.БАЗАРПҮРЭВ**

*Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхимийн багш*

**С.БААСАНДОЛГОР**

*Улс төр судлалын тэнхимийн магистрант*

**Түлхүүр үг:** Сонгууль, орон нутгийн сонгууль, иргэдийн улс төрийн оролцоо, улс төрийн оролцооны төвшин

**Хураангуй:** Сонгуульд оролцох иргэдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол буурч байна. 2016 оны орон нутгийн сонгууль дээр уг байдал нь давтагдсан юм. 2016 оны орон нутгийн сонгуульд Хан-Уул дүүргийн иргэдийн оролцооны талаар уг өгүүлэлд авч үзсэн бөгөөд иргэдэд орон нутгийн сонгуулийн ач холбогдлыг ойлгуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.

\* \* \*

Сонгуульд оролцох иргэдийн тоо сонгуулийн жилүүдэд тогтмол буурч ирсэн нь засаглагч, төрийн бюрократ системийн төлөөлөгч мөн уг сэдвийг дагнан нарийвчлан судалж буй эрдэмтдийн анхаарлыг ихээр татан түүнийг тал талаас нь тайлбар өгч, санал өгөх иргэдийн идэвхийг нэмэх арга замыг бодож олох ажил хийгдэх болов.

Сонгуульд үл оролцох шалтгаан олон янз байдгийг эрдэмтэд тогтоосон байдаг. Хэд хэдэн шалтгааныг дурьдаж болох юм.

- Засаглалд үзүүлэх итгэл алдсан
- Эдийн засгийн нөхцөл байдал муудсан
- Цаг агаар
- Мэдээлэл хомс
- Сурталчилгаа, ухуулгын ажилд саад болох
- Санхүүгийн хүндрэл
- Халз мэтгэлзээн бага хийдэг
- Сонгуулийг шударга бус, бохир гэж үзэх хандлага газар авч байна.

Улс төрийн оролцооны нөөцөд суурилсан энэ хандлага нь сонгогчдын санал өгөх үйл явц дээр голлон төвлөрдөг бөгөөд улс төрийн оролцоог тогтооход сонгуулийн үр дүн хамгийн чухал гэж үздэг судлаачид улс төрийн оролцооны дайчилгааны загварыг санал болгосон.

Судлаач П.Норрис улс төрийн оролцооны хэтийн төлөвийг дайчилгааны загвар тодорхойлж болох юм гээд энэ нь улс төрийн албадлагыг хэрэгжүүлэх улс төрийн байгууллагуудтай холбоотой гэж үзсэн байна. Улс төрийн нам болон улс төрийн байгууллагуудын гол шинж нь хувь хүний улс төрийн оролцооны боломжийг бий болгож, хүмүүсийг улс төрийн амьдралд татан оролцуулахад голлон анхаарч байдаг.

С.Розенстоун, М.Хансен нар улс төрийн оролцооны дайчилгааны загвар нь улс төрийн сонгуулийн оролцоо, сонгуулийн бус оролцоо гэсэн хоёр хэлбэрээр илэрчбайна гэж үзсэн. Улс төрийн манлайлагчид сонгуулийн бус оролцоонд анхаарч ажилладаг. Үүнтэй уялдуулан улс төрийн үйл ажиллагаанд оролцох, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сонсогчдод нөлөөлөх, нийгмийн үнэлэмжийн төвшинг харгалзан үйл ажиллагаа зохион байгуулна.

Харин сонгуультай холбоотой иргэдийн улс төрийн оролцоог улс төрийн нам, түүний аппарат чиглүүлж байдаг гэж үзсэн байна. Улс төрийн байгууллага, бүтэц нь хувь хүний улс төрийн оролцооны төвшинг нэмэгдүүлж байдаг гэж үзжээ. Дайчилгааны загвар нь олон нийтийн санаа бодлыг татаж иргэдийн улс төрийн оролцооны төвшинг нэмэгдүүлэхийг гол болгон зорьдог байна.

Иргэд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, эрүүл орчинд амьдрах эрхээ мэдэж, эдгээр эрхүүд зөрчигдсөн тохиолдолд зөрчлийг арилгуулахын тулд тодорхой үйл байдал үзүүлэх, үйлдэл хийх боломжоор хангагдсан байх ёстой. Монгол улсад иргэдийн улс төрийн оролцооны эрхийг:

- Монгол улсын Үндсэн хууль



- Улс төрийн намын тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрхийн тухай хууль,
- Жагсаал цуглаан зохион байгуулах тухай зэрэг хуулиар баталгаажуулсан.

Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 1-т “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан нь иргэдийн шууд болон шууд бус улс төрийн оролцооны эрх зүйн үндэс болно.

Сонгуулийн эрх зүйн үндсэн зарчимд:

- Сонгууль бүх нийтийн байх
- Сонгууль шууд байх
- Чөлөөтэй байх
- Саналаа нууцаар гаргах зарчмууд хамаарна.

Түүнчлэн Монгол улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно”, 21 дүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно” гэж иргэдийн сонгох болон сонгогдох эрхийг тодорхойлсон байна.

Монгол улсын Үндсэн хуульд иргэний улс төр, нийгэм, соёл, эдийн засаг, хувь хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсон 18 заалт байгаа бөгөөд тэдгээрээс 5 заалт нь иргэдийн улс төрийн оролцоог тодорхойлсон агуулгатай байна. Үүнд:

- Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно.
- Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй.
- Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Харин төрийн улс төрийн албан тушаалтнаас бусад албан хаагчийн намын гишүүнчлэлийг түдгэлзүүлнэ.
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

2016 оны 10 сарын 19 ны өдөр орон нутгийн сонгууль болсон. Иргэдийн улс төрийн оролцооны байдлыг судлахдаа 2016 оны орон нутгийн сонгуулийн Хан – Уул дүүргийн сонгогчдын оролцооны идэвхид анализ хийж, орон нутгийн сонгуулийн оролцоо ямар төвшинд байсныг, иргэдийн улс төрийн оролцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийг тайлбарлахыг зорьлоо.

Хан-Уул дүүрэг нь 16 хороотой бөгөөд 2015 оны байдлаар 150946 иргэдтэй. Үүнээс нэрсийн жагсаалтанд бичигдсэн сонгогчдын тоо – 99961.

**Санал өгсөн сонгогчдыг хүйсээр нь авч үзвэл:**

Нийт нэрсийн жагсаалтанд 99961 иргэн бүртгэлтэй байснаас 56738 нь саналаа өгсөн. Үүнээс эмэгтэй – 31649, эрэгтэй – 25126.

Нийгмийн харилцаанд хүмүүс хүйсийн ялгаатай байдлаас үүдэн харилцан адилгүй үүрэг хүлээдэг. Энэ байдал нь тэдний улс төрийн оролцоонд мөн адил тодорхой байдлаар тусгалаа олдог. Тухайлбал, нийгмийн үүрэг нь ялгаатай байдгаас шалтгаалан эрэгтэйчүүдийн улс төрийн оролцоо эмэгтэйчүүдээс илүү байдаг. Учир нь эмэгтэйчүүд хүйсийн онцлогоос үүдэн хүүхэд төрүүлэх, асрах, гэрийн ажил хийх үүрэг хүлээдэг нь тэдний улс төрд оролцох бололцоог багасгадаг. Эмэгтэйчүүдийн гэр бүлийн үүрэг нь тэдний нийгэм-эдийн засгийн байр суурийг тодорхойлох шинжтэй байдаг бөгөөд улмаар улс төрийн оролцоонд нь ямар



нэг байдлаар нөлөөлдөг. Гэхдээ тухайн улсын нийгмийн хөгжлийн түвшин ямар байхаас шалтгаалж эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хүлээн зөвшөөрөх байдал ялгаатай байж болно. Сонгуульд саналаа өгсөн эрэгтэй хүнээс 12%-иар эмэгтэйчүүд илүү оролцсон байна.

**Санал өгсөн сонгогчдыг насны бүлгээр авч үзвэл:**

Нэрсийн жагсаалтанд 99961 хүн бичигдсэнээс 56646 буюу нийт хүн амын 51% нь орон нутгийн сонгуульд оролцжээ. Хан-Уул дүүрэгт санал өгсөн сонгогчдыг дараах насны бүлэгт хувааж үзлээ.

- 18 – 25 нас – 7581 иргэн
- 26 – 40 нас – 22066 иргэн
- 41 – 55 нас – 16266 иргэн
- 65-с дээш – 10773 иргэн

Тодорхой насны бүлгийн улс төрийн сонирхол, хандлага харилцан адилгүй байдаг. Улс төрийн оролцооны талаар хийгдсэн судалгаа нь нийгмийн гишүүдийн нас улс төрийн оролцоонд нөлөөлж байгааг харуулсан байна.

Улс төрийн оролцооны талаар хийгдсэн судалгаанаас харахад нийгмийн дундаас дээш насныхан оролцоо илүү өндөр байдаг байна. Дундаас дээш насныхны нийгмийн итгэл үнэмшил, үнэт зүйл нь тогтсон байдаг бөгөөд нийгмийн хариулцлага өндөрсөж, улс төрийн үйл явц хувь хүний болон нийгмийн амьдралыг тодорхойлох шинжтэй гэдгийг ухамсарлан ойлгосон байдаг байна.


Дундаас дээш насныхны улс төрийн сонголт тогтсон эсхүл албан тушаал дэвших, нийгмийн байр сууриа бэхжүүлэх хэрэгцээ нь нэмэгдэж улс төрийг сонирхох, оролцох хандлага давамгайлдаг байна.

Хан –Уул дүүрэгт сонгуульд оролцсон иргэдийн насны байдлаас харвал нийт сонгогчдын 2/4 нь дундаас дээш буюу 26 – 40 насныхан байна.

Нийт 46 хэсгийн хороонд иргэд сонгогчдоос санал авсан. Орон нутгийн сонгуульд нэрсийн жагсаалтанд бичигдсэн иргэдийг хороогоор авч үзвэл:

Зураг 1.


**Хан – Уул дүүргийн хороодын сонгогчдын тоо**



Орон нутгийн сонгуулийн санал хураалт өглөө 07:00 цагаас Монгол орон даяар зэрэг эхэлсэн. 07:00 -12:00 цаг хүртэл нийт санал өгсөн иргэдийн 36 хувийг 41 – 55 насныхан эзэлж байсан. 18 – 25 насныхан 4 -5 хувийг эзэлж байсан байна. 12 цагийн байдлаар нийт сонгогчдийн 23,1% нь саналаа өгсөн байна.


Зураг 2.

**Орон нутгийн сонгуулийн санал хураалт 12 цагийн байдлаар**





Нэмэлт санал хураалтын дүн




Нэмэлт санал хураалт 2016 оны 10 сарын 23-нд явагдсан. Нийт сонгогчдын ирц нэмэлт санал хураалтын дараагаар 51 хувьд хүрсэн.

2016 оны орон нутгийн сонгуульд оролцосон сонгогчдын оролцооны байдлаас харгалзан дараах дүгнэлт гарч байна.

- 1992 оны УИХ-ын сонгуульд сонгогчдын 92 хувь нь оролцсон бол түүнээс хойш сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчдын ирц буурсаар 2012 онд 50 гаруйхан хувьд хүрсэн билээ. Харин өнгөрсөн зун болсон УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуулиар ирц харьцангуй нэмэгдсэн. Гэтэл сум, дүүргийн ИТХ-ын сонгуулиар энэ үзүүлэлт буурсан. Цөөхөн сарын дотор сонгогчдын ирц хол зөрүүтэй хэлбэлзэж, сум дүүргийн ИТХ-д ач холбогдол өгөхгүй мөн иргэдийн улс төрийн оролцоо буурч байна.
- Орон нутгийн сонгуульд оролцох залуучуудын идэвхи улс төрийн оролцооны талаар хийгдсэн судалгаанаас харахад 18 – 25 насны залуус улс төрийг бага сонирхож байна. 2016 онд Конрад Аденаур сангаас хийгдсэн “Залуучуудын улс төрийн оролцоо” судалгаанаас авч үзвэл:

Зураг 6.

Залуучуудын улс төр сонирхох байдал



Дээрх судалгаанаас үзвэл дөрвөн залуу хүний нэг нь буюу 25 хувь нь улс төрийг сонирхож байгаа бол гурван залуу тутмын нэг нь буюу 29,5 хувь нь хааяа сонирхдог, хоёр залуу тутмын нэг нь буюу 45,5 хувь нь улс төрийн сонирхолгүй байх хандлагатай байна.



## Дүгнэлт

Ардчиллын үйл явцын гажуудлыг засах, үндсэн зарчмыг алдагдуулахгүй байхад иргэний оролцоог бодитойгоор хангах нь чухал юм. Олон ургалч үзэл нэрээр халхалсан намын гажуудсан тогтолцоо нь иргэдийг талцуулж, хагалан бутаргах, цаашилбал үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц байдлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх чөлөө эв нэгдлийг хангах, нам төвтэй засаглалаас иргэн төвтэй засаглалруу шилжих, төлөөллийн ардчиллаас шууд ардчилал руу шилжих, засаглалыг хувиарлах зарчимд өөрчлөлт хийх, хууль санаачлахад нийгэмд тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад иргэдийн саналыг тусгах, хууль батлах процессийг луйваргүй болгох, намын ардчиллыг иргэний ардчиллаар солих зэрэг асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн санал санаачлага төрийн бус байгууллагын идэвхтэй оролцоо туйлын чухал юм.

Иргэдийн улс төрийн оролцоог Нийслэлийн Хан-Уул дүүргийн орон нутгийн сонгуулийн сонгогчдын үйл байдал, оролцоотой холбоотой холбон судлахад түүний эерэг сөрөг тал, үйл явц, эрх зүйн нарийн зохицуулалтгүй байдал, алдаа дутагдал цөөнгүй байгаа нь ажиглагдаж байна. Иймд дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Сонгогчдын оролцоо буурах хандлага ажиглагдаж байгаа нь сонгогч хувь хүнтэй холбоотой төдийгүй сонгуулийн зохион байгуулалттай, сонгуулийн үр дүнтэй, сонгогдож байгуулагдсан төр засгийн байгууллагуудын талааарх олон нийтийн үнэлэмжтэй холбоотой. Монголчуудын улс төрийн оролцоо нь төр улсын түүхийн бүхий л үед өөрийн гэсэн өвөрмөц онцлогтойгоор хөгжиж ирсэн. Улс төрийн намд итгэх иргэдийн итгэл буурсан, сонгуулийн тухай хуулийг эрх барьж буй хүчний зүгээс өөрсдийн эрх ашигт нийцүүлж өөрчилдөг, иргэдийн амьдрал ахуйд дорвитой өөрчлөлт гараагүй мөн сонгогдож гарсан улс төрчидтэй холбоотой хээл хахууль гэмт хэргийн шинжтэй асуудлууд ихээр гарах болсон гэх мэт шалтгааны улмаас иргэдийн улс төрийн оролцоо буурч байна.
- Сүүлийн жилүүдэд нэг сонгуулиас нөгөө сонгуульд улс төрийн намд санал өгөлтөө өөрчилдөг буюу хөвдөг сонгогчдын тоо нэмэгдэж, нийт сонгогчдын 30-аад хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл манай улсын гурван хүн тутмын нэг нь улс төрийн аль нэг намыг дэмждэггүй гэсэн үг юм.
- Монголын сонгогчдын улс төрийн намыг дэмжих байдал буурч, үүний оронд эдийн засгийн шинжтэй бэлэн болон бэлэн бус мөнгөний амлалт, уриа лоозон бүхий популистуудад татагдах явдал нэмэгдсээр байна.
- Нийт сонгогчдын 25-30 хувь нь санал хураалтын сүүлийн долоо хоног хүртэл хэнд саналаа өгөхөө шийдээгүй байдаг нь сонгуулийн үеэр хийгдсэн судалгаануудаас харагдаж байна.
- Өнөөдөр улс төрийн зарим харилцааны эрх зүйн зохицуулалтыг улс төрийн намуудын хоорондын тохиролцоо, зөвшилцөл орлож шийдвэрлэсээр байна. Иймд улс төрийн намын тухай хууль, сонгуулийн тухай хуулиудыг улам боловсронгуй болгон өөрчлөх шаардлагатай юм. Ингэхдээ намуудын бүтэц зохион байгуулалт, дотоод ардчиллын асуудал, сонгуулийн үйл явцын үе шат бүрт сонгуульд оролцогч субъектүүдийн оролцоо, сонгуулийн кампанит ажлын үе шат бүрийн нарийн чимхлүүр ажлыг нэг бүрчлэн судалж хуулийн зохицуулалт хийх хэрэгтэй.
- Мөн сонгогчдод сонгуулийн шинэ хуулийн талаар сайтар сурталчлан хэсэг тойрогтой, хэдэн мандаттай, саналын хуудсанд тэмдэглэгээг яаж хийх талаар тодорхой мэдээлэл өгөх, сонгогчдын нэрийн жагсаалтын маргаан будлианыг эцэслэн бүртгэл мэдээллийг алдаагүй болгож чадвал сонгууль зөв шударга явагдах эхлэл тавигдана.
- Сонгуулийн үеэр нам эвслээс сонгогчдыг мөнгө болон эд зүйлээр худалдаж авах сөрөг хандлага ихэссэн бөгөөд энэ нь ардчилсан сонгуулийн үйл явцад буруугаар нөлөөлж байна. Энэ нь дундаас доош орлоготой буюу эмзэг давхаргынханд голлох нөлөө үзүүлж байна. Сүүлийн жилүүдэд сонгуульд нэр дэвшигчид бэлэн мөнгө их хэмжээгээр амлацгааж байгаа нь үүнтэй холбоотой юм. Мөн сонгуулийн оролцооны дүнд улс төрийн намууд ч нөлөөлөх хандлага байна.
- Сонгуулийн өмнө сонгуулийн систем болон сонгуулийн хуулийг өөрчлөхөөр шийдвэр гаргуулахыг хичээдэг гэх мэт ардчилсан сонгуулийн үнэ цэнийг алдагдуулдаг сөрөг нөлөө ажиглагдаж байна.
- Мөн баг хороо, сум, дүүргээс эхлээд засаг захиргааны бүх нэгжинд иргэдийн бүртгэл судалгааг сайжруулж, сонгогчдын үүрэг хариуцлагыг сануулж, соёлтой ухаалаг хандлагыг төлөвшүүлэх хэрэгтэй.
- Сонгуульд нэр дэвшигчдэд нэр дэвших шалгуур үзүүлэлт, цензурыг тодорхой болгож улс төрийн өндөр мэдлэг боловсрол, чадвартай удирдагчдыг сонгох нөхцөл бололцоог бүрдүүлэх нь чухал асуудал юм.



Улс төрийн намуудын санхүүжилтийн асуудал, түүнийг тооцох аргачлал, нэр дэвшигчдийн хоосон болон бодит амлалт, сонгогчдын бүртгэл, сонгуулийн байгууллагын болон түүнд ажиллагчдын хариушлага, сонгогчдын боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагуудын зүгээс үнэн бодит, тэнцвэртэй мэдээлэл түгээх замаар сонгуулийн бүхий л үйл явцад үр ашигтай хяналт тавих хэрэгтэй.

**Abstract:** The number of participants in election has systematically decreased. The same issue appeared in regional election, which took place in 2016. It is important to explain the essence of regional election to citizens and to improve citizen's participation in it.

## НОМ ЗҮЙ:

### А. Ном зохиол

1. Роберт Даль. Ардчиллын тухай УБ., 2004.
2. Ё.Довчин. Улс төр судлал УБ., 2002.
3. Ё.Довчин. Харьцуулсан улс төр УБ., 2006.
4. МУИС. Улс төрийн шинжлэх ухаан УБ., 2001.
5. С.Базарпүрэв. Улс төрийн шинжлэх ухаан /хураангуй лекц/. УБ., 2005.
6. А.Цанжид. Улс төрийн шинжлэх ухаан УБ., 2005.
7. Д.Загджав. Монгол дахь иргэдийн улс төрийн орлоо өөрчлөлт УБ., 2002.
8. Ю.Агар. Ардчилсан тогтолцоонд шилжих үеийн төр нийгмийн харилцааны асуудлууд УБ., 2001.
9. А.Юндэндорж. Нийгэм иргэнийг ардчилсан хэм шинжийг олоход төрийн институтийн гүйцэтгэх үүрэг УБ., 2001.
10. Ардчиллын төлөө иргэний нийгмийн түншлэл олон улсын иргэний нийгмийн чуулган илтгэлүүдийн товчлол ба чуулганы баримт бичгийн эмхтгэл УБ., 2003.
11. ММНХ Иргэн түншлэгч болох нь УБ., 2002
12. Ардчилсан төрийн сонгуулийн товчоон УБ., 2005.
13. Монголын парламентын үүсэл хөгжил тайлбар баримт сэлт лавлагаа УБ., 2004.
14. УБТА. Зүүн Азийн барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа УБ., 2008.
15. УБТА. Азийн барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2008.
16. Монгол улс дахь сонгууль сонгуулийн шинэ тогтолцоо ред А.Жамбал УБ., 2000.
17. Монгол улсын үндсэн хуулинд тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. УБ., 2004.
18. УБТА. Улс төрийн лекцийн эмхтгэл. УБ., 2001.
19. Монголын парламентын үүсэл хөгжилт. УБ., 2003.
20. Д.Оюунцэцэг. Олон нийтийн санаа бодлын социологи. УБ., 2000.
21. Н.Цолмонтуяа. Сонгогчдын боловсрол /сургалтын гарын авлага/. УБ., 2008.
22. Б.Дэлгэрмаа. Улс төр судлал. УБ., 2001.
23. ММНХ. Ардчиллын засаглал нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2006.
24. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтын гарын авлага. УБ., 2009.

### Б. Судалгааны баримт бичгүүд

25. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5 дугаар бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт Монгол дахь засаглалын төлөв байдал үнэлгээ УБ., 2006.
26. Ардчиллыг шинээр бий болгосон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5 бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт УБ., 2008.
27. Улс төрийн боловсролын академи Зүүн Азийн барометр Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа УБ., 2003.
28. Улс төрийн боловсролын академи Зүүн Азийн барометр Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа УБ., 2006.

### В. Гадаад хэл дээр ашигласан ном зохиолууд

29. Bruce Russell "Controlling the Sword: The Democratic Governance of National Security". Harvard University Press., 1990.
30. Основы политической науки. Учебное пособие. Часть I. М., 1994.
31. Юриев.А.И Введение в политическую психологию. М., 1992.

### Г. Хууль тогтоомж

32. Монгол улсын үндсэн хууль 1992.
33. Монгол улсын их хурлын тухай хууль 2006.
34. Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль 1995.
35. Хууль УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах өргөн мэдүүлэх журмын тухай хууль 2001.